



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

БИЗНЕС ИТГЭЭЛИЙН ИНДЕКС

2018

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

БИЗНЕС ИТГЭЛИЙН ИНДЕКС

МҮХАҮТ 2019. “Бизнес итгэлийн индекс 2018” судалгааны зохиогчийн албан ёсны эрхийг МҮХАҮТ эзэмшинэ. Энэхүү мэдээллийг цааш түгээж байгаа бол зохиогчийн нэр болон эх сурвалжийг заавал дурдана уу.



АГУУЛГА

| | |
|--|----------|
| ХУРААНГУЙ | 2 |
| БИЗНЕС ИТГЭЛИЙН ИНДЕКС | 3 |
| Бизнесийн орчны үнэлгээ | 3, 4 |
| Бизнесийн ашиг орлогын үнэлгээ | 4 |
| Хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ | 4, 5 |
| Макро эдийн засгийн орчны үнэлгээ | 5–7 |
| Бизнесийн орчны шийдвэрлэвэл зохих асуудлууд | 7 |
| СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ | 8 |


ХУРААНГУЙ

МҮХАЙТ-аас бизнесийн орчны ерөнхий төлөв байдал, хөрөнгө оруулалтын орчин, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого, макро эдийн засгийн үндсэн асуудал болох ядуурал, ажилгүйдэл, инфляцийн талаар бизнес эрхлэгчдийн байр суурь, цаашид хэрхэн өөрчлөгдөх талаар хүлээлт, бизнесийн орчны сайжруулбал зохих асуудлууд зэрэг үзүүлэлтүүдээр бизнесийн орчныг үнэлэх зорилготой “Бизнесийн итгэлийн индекс” судалгааг 18 дах жилдээ явууллаа.

“Бизнес итгэлийн индекс” судалгааны асуулгыг Улаанбаатар хот, орон нутгийн нийт 845 бизнес эрхлэгчдийн дунд ярилцлага ба онлайн хэлбэрээр 2019 оны 4-6 саруудад явуулж гарсан үр дүнг хүргэж байна.

Бизнес итгэлийн ерөнхий индекс 2018 онд 0.47 гарсан нь сүүлийн 6 жилийн хугацаанд анх удаагийн эерэг үр дүн болж байгаа бөгөөд 2017 онтой харьцуулахад 0.79 нэгжээр өссөн байна. Бизнес итгэлийн индекс эерэг утгатай байгааг эдийн засгийн өсөлт, ялангуяа ГШХО, түүхий эдийн үнийн өсөлт, томоохон төслүүдийн бүтээн байгуулалттай холбон үзэж болно.

2018 онд бизнес эрхлэгчдийн орчиндоо итгэх итгэлийн бүх үзүүлэлтүүдэд өгсөн дундаж үнэлгээ эерэг байгаа бөгөөд 2017 оноос өссөн дүнтэй байна. Нийт судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 54 хувь нь бизнесийн ерөнхий орчин өмнөх жилээс сайжирсан, дунджаар 24 хувь нь макро эдийн засгийн орчин сайжирсан гэж үзжээ.



Бизнесийн орчныг хэмжих бодит үзүүлэлт болох ашиг, орлогын үзүүлэлт нь 2017 онд 25 нэгж хувийн өсөлттэй гарч байсан бол 2018 онд бизнес эрхлэгчдийн 58 хувь нь ашиг орлого өмнөх оноос тодорхой хэмжээнд өссөн гэсэн байна.

Хөрөнгө оруулалтын үзүүлэлтийн хувьд 2018 оны эерэг үнэлгээ нь өмнөх оноос 20 нэгж хувиар өссөн дүнтэй байна. Харин 2019 оны хөрөнгө оруулалт хийх хүлээлт нь өмнөх оноос 1 нэгж хувиар буурчээ.

2018 онд бизнесийн орчны тулгамдсан асуудлаар эхний 2 байранд “Зээлийн хүү өндөр, хугацаа богино”, “Бодлогын тогтворгүй байдал” гэж нэрлэсэн нь өмнөх жилээс өөрчлөлтгүй байна.

Судалгаанд оролцогчид 2018 оны хувьд бизнесийн орчинд өмнөх оноос илүү сайн дүн тавьсан бөгөөд харин 2019 оны бизнес эрхлэх орчны хүлээлтийн талаар өмнөх жилүүдээс төдийлөн сайжрахгүй гэж үзсэн байна.

БИЗНЕС ИТГЭЛИЙН ИНДЕКС

Бизнес итгэлийн индексийг бизнесийн орчин, ашиг, орлогын өөрчлөлт, хөрөнгө оруулалт, макро эдийн засгийн орчин гэсэн үндсэн 4 үзүүлэлтээр тооцож гаргадаг. 2017 оноос эхлэн олон улсын аргачлалын дагуу Бизнес итгэлийн индексийг тооцохдоо үзүүлэлт бүрээр судалгаанд оролцогсдын эерэг болон сөрөг үнэлгээний зөрүүгээр тооцон гаргадаг болсон.


2012-2018 оны Бизнес итгэлийн индексийг үзүүлэлт тус бүрээр мөн ерөнхийлж тооцсон дүнг Хүснэгт 1-ээр үзүүлээ.

Хүснэгт 1. Бизнес итгэлийн индекс (2012-2018)

| Үзүүлэлтүүд | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | Δ 2018/2017 |
|--|-------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|-------------|-------------|
| Бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ | 0.03 | 0.04 | -0.28 | -0.46 | -0.36 | -0.07 | 0.12 | 0.19 |
| Ашиг, орлогын өөрчлөлтийн үнэлгээ | 0.28 | 0.11 | -0.01 | 0.10 | -0.22 | -0.02 | 0.18 | 0.20 |
| Хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн үнэлгээ | 0.50 | 0.02 | -0.10 | -0.22 | -0.30 | 0.14 | 0.40 | 0.26 |
| Макро эдийн засгийн орчны үнэлгээ | -0.23 | -0.45 | -0.47 | -0.46 | -0.30 | -0.37 | -0.23 | 0.14 |
| Бизнес итгэлийн индекс | 0.58 | -0.27 | -0.87 | -1.04 | -1.18 | -0.32 | 0.47 | 0.79 |

Бизнес итгэлийн 2018 оны ерөнхий индекс нь 0.47 гэсэн дүнтэй гарсан. Энэ нь 2017 онтой харьцуулахад 0.79 нэгжээр өссөн үзүүлэлт бөгөөд 2013 оноос хойш анх удаа бизнес итгэлийн индекс эерэг утгатай гарлаа. Бизнесийн орчинд итгэх итгэл 2016 он хүртэл 5 жил дараалан буурч байсан бол сүүлийн 2 жил дараалан өссөн дүнтэй байна. (Зураг 1)

Индексийг үзүүлэлт тус бүрээр авч үзвэл, 2018 онд бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээний индекс нь 0.19 нэгжээр, ашиг орлогын өөрчлөлтийн үнэлгээний индекс 0.2 нэгжээр, хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн үнэлгээний индекс 0.26 нэгжээр, макро эдийн засгийн үнэлгээний индекс нь 0.14 нэгжээр тус тус өссөн байна.



1 | БИЗНЕСИЙН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

2018 онд эдийн засгийн идэвхжил үргэлжилж, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 6.9 хувьд хүрч, инфляци зорилтот түвшнээс бага буюу 7.3 хувьд хадгалагдсан бөгөөд гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр хөрөнгө оруулалт өссөн. Түүнчлэн дэлхийн зах зээлд экспортын гол нэр төрлийн түүхий эдийн үнэ харьцангуй өндөр, эрэлт их байсан нь экспортын хэмжээг нэмэгдүүлж, эдийн засагт эерэг нөлөө үзүүлжээ.


Судалгаанд оролцогсдын 54 хувь нь 2018 онд бизнесийн орчин өмнөх жилээс “сайжирсан” үнэлгээ өгсөн ба энэ үзүүлэлт нь өмнөх жилээс 19 нэгж хувиар өссөн байна.

Бизнесийн орчин 2019 онд хэрхэн өөрчлөгдөх тухай асуултанд нийт судалгаанд оролцогсдын 66 хувь нь өмнөх жилээс ямар нэгэн хэмжээгээр сайжирна гэсэн хүлээлттэй байгаа ба энэ нь 2017 оноос 12 хувиар өссөн дүнтэй байна. 2018 оны хувьд бизнес эрхлэгчдийн үнэлгээ ба хүлээлтийн зөрүү ойролцоо дүнтэй гарчээ.



2 | БИЗНЕСИЙН АШИГ ОРЛОГЫН ҮНЭЛГЭЭ

2018 онд нийт судалгаанд оролцогсдын дунджаар 58 хувь нь өмнөх жилээс ашиг, орлогын түвшин тодорхой хэмжээнд өссөн гэж хариулсан ба энэ нь өмнөх жилээс 18 нэгж хувиар өссөн дүнтэй байна. Харин 2019 онд ашиг орлого хэрхэн өөрчлөгдөх тухай асуулгад нийт судалгаанд оролцогсдын 72 хувь нь ямар нэг хэмжээгээр өснө гэсэн эерэг хүлээлттэй байна. 2017 оны судалгаагаар нийт судалгаанд оролцогсдын 64 хувь нь 2018 онд бизнесийн ашиг орлого ямар нэг хэмжээгээр өснө гэж хүлээж байсан бол 2018 оны бодит үнэлгээгээр 58 хувь нь өссөн гэсэн нь төсөөлснөөс 6 нэгж хувиар доогуур байна.



3 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийн дунд хугацааны өсөлтөд нөлөөлөгч гол үзүүлэлтүүдээр хөрөнгө оруулалт, экспортын өсөлтийг нэрлэсэн. Монгол Банкны мэдээгээр 2018 онд дотоод болон гадаад түншийн итгэл, бизнесийн зээл

олголт өсөж, ГШХО нэмэгдсэнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалт өмнөх оноос 27.2 хувиар өсч, эдийн засгийн өсөлтөд 10 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн байна.

Бизнес итгэлийн индекс судалгаагаар 2018 онд бизнестээ ямар нэгэн хөрөнгө оруулалт хийсэн эсэх талаар бизнес эрхлэгчдээс тодруулан асуухад 70 хувь нь хөрөнгө оруулалт “хийсэн” гэсэн хариулт өгсөн ба энэ нь өмнөх оноос 13 нэгж хувиар өсчээ.

2017 оны судалгаанаас бизнес эрхлэгчдийн 2018 онд хөрөнгө оруулах тухай хүлээлт нь 79 хувь байсан бол 2018 оны бодит үнэлгээгээр 70 хувь нь хөрөнгө оруулалт хийж, бодит хөрөнгө оруулалт нь төсөөллөөс 9 нэгж хувиар доогуур байна.

2017 онд судалгаанд оролцогсдын 79 хувь нь дараагийн жилд ямар нэг хөрөнгө оруулалт хийнэ гэсэн эерэг хүлээлттэй байсан нь хамгийн өндөр дүн болох 2012 оны 82 хувьд дөхөж очсон үзүүлэлт болж байсан бол 2018 оны судалгаагаар уг үзүүлэлт нь 78 хувь болж өмнөх оноос 1 нэгж хувиар буурсан дүнтэй байна.



4 | МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

Бизнесийн итгэлийн индексийг тооцоход ашигласан 4 дэх үзүүлэлт нь макро эдийн засгийн орчин буюу инфляци, ажилгүйдэл, ядуурлын үзүүлэлтийн үнэлгээ ба хүлээлт юм.

2018 онд эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлын хэмжээ нэмэгдэж, ажил эрхлэлтийг дэмжин ажилгүйдлийн түвшин өмнөх оноос 1 хувиар буурч 7.8 хувь болжээ. Монгол улсын дотоод эдийн засгийн идэвхжил, томоохон төслүүдийн бүтээн байгуулалт нь ажил эрхлэлтийг дэмжих замаар хүн амын худалдан авах чадварыг сайжруулан, эрэлтийн гаралтай инфляцийг бий болгож байна. Нөгөө талаас 2017 оны ургац алдалт, газрын тосны үнийн өсөлт зэрэг нь нийлүүлэлтийн шинж чанартай үнийн өсөлтийг бий болгон инфляци хэлбэлзэхэд нөлөөлсөн байна.

2018 оны судалгаагаар макро эдийн засгийн үндсэн асуудлууд болох инфляцийн түвшин, ажилгүйдлийн түвшин, ядуурлын түвшин зэрэг үзүүлэлтүүдийн өөрчлөлтийн “сайн” үнэлгээ нь өмнөх онтой харьцуулахад өссөн байгаа боловч, эдгээр үзүүлэлтүүдийн “хангалтгүй” үнэлгээ өссөн байна. 2018 оны макро эдийн засгийн үнэлгээнд судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 24 хувь нь өмнөх оноос сайжирсан гэсэн үнэлгээ өгсөн бол 47 хувь нь өмнөх оноос ямар нэгэн дорвитой өөрчлөлт гараагүй эсвэл нөхцөл байдал муудсан гэж үзсэн байна.



ИНФЛЯЦИ

2018 онд судалгаанд оролцогсдын 26 хувь нь инфляцийн түвшин ямар нэг хэмжээгээр буурсан гэж үзсэн ба энэ нь өмнөх оноос 9 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм. Харин судалгаанд оролцогсдын 56 хувь нь инфляцийн түвшин өмнөх онтой харьцуулахад ахиц гараагүй, өссөн гэж үзсэн ба энэ нь өмнөх оноос 3 нэгж хувиар буурсан дүнтэй байна.

2017 онд судалгаанд оролцогсдын 39 хувь нь инфляцийн түвшин буурах хүлээлттэй байсан нь сүүлийн 6 жилийн хамгийн эерэг дүн байсан бол энэ нь 2018 онд 23 хувь болж 13 нэгж хувиар буурсан. Харин судалгаанд оролцогсдын 51 хувь нь ирэх жил инфляци ямар нэг хэмжээгээр өснө гэсэн хүлээлттэй байгаа нь өмнөх оноос 14 нэгж хувиар өсчээ.



АЖИЛГҮЙДЭЛ

2018 онд судалгаанд оролцогсдын 26% нь ажилгүйдэл буурсан гэсэн хариулт өгсөн ба энэ дүн нь өмнөх оноос 13 нэгж хувиар өссөн байна. Харин 2017 оны судалгаагаар судалгаанд оролцогсдын 51 хувь нь ажилгүйдлийн түвшин ямар нэг хэмжээгээр өссөн гэж үзэж байсан бол энэ дүн 2018 онд 43 хувь болж өмнөх оноос 8 нэгж хувиар буурсан байна.

2019 онд ажилгүйдлийн түвшин хэрхэн өөрчлөгдөх тухай тодруулан асуухад судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 33 хувь нь дараагийн жилд ажилгүйдлийн түвшин буурна гэж хариулсан бөгөөд энэ нь өмнөх оноос 3 нэгж хувиар буурсан байна. Ажилгүйдлийн түвшинг судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 43 хувь нь өснө эсвэл ямар нэгэн өөрчлөлт гарахгүй гэж хариулсан бөгөөд энэ нь өмнөх оноос өссөн дүн юм.






ЯДУУРАЛ

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Дэлхийн банктай хамтран “Ядуурлын дүр төрх-2016” ядуурлын тооцооны үр дүнгээр Монгол улсын ядуурлын түвшин 2014 онд 21.6 хувь байсан бол 2016 онд 29.6 хувьд хүрч 8.0 пунктээр өсжээ. Энэ нь 2016 оны нийт хүн ам болох 3 сая хүнээс 907.5 мянган хүн нь ядууралд өртсөн байгааг илтгэх үзүүлэлт юм.

2018 оны судалгаанд оролцогсдын 19 хувь нь ядуурал буурсан гэж үзсэн ба энэ нь 2017 оны үнэлгээтэй харьцуулахад 8 нэгж хувиар өссөн байна. 2017 онд судалгаанд оролцогсдын 56 хувь нь ядуурлын түвшин өссөн гэж үзэж байсан бол энэ дүн нь 2018 онд 66 хувь болж өмнөх оноос 10 нэгж хувиар өссөн байна.

Ядуурлын түвшний талаар судалгаанд оролцогсдын 28 хувь нь ирэх жил буурна гэсэн хүлээлттэй байгаа ба энэ нь өмнөх жилээс 3 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм.

Ядуурлын түвшин



5 | БИЗНЕСИЙН ОРЧНЫ ШИЙДВЭРЛЭВЭЛ ЗОХИХ АСУУДЛУУД

Дэлхийн банкнаас орнуудын эдийн засгийн үр ашигтай байдлыг хэмжих зорилготой “Бизнес эрхлэлтийн индекс” (Doing business index)-ийг гаргадаг. Мөн Дэлхийн банкны эдийн засагчдын хийсэн судалгаагаар Бизнес эрхлэлтийн индекс ба тухайн орны бүтээмж нь хоорондоо эерэг хамааралтай байдаг бөгөөд Бизнес эрхлэлтийн индекс өндөртэй орон нь илүү өндөр бүтээмжтэй байдаг байна. Өөрөөр хэлбэл бизнесийн тогтвортой, сайн орчин нь илүү өндөр бүтээмжийг бий болгодог байна. Иймд энэ хэсэгт тогтвортой, тааламжтай бизнесийн орчинг бүрдүүлэхэд нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлын талаар судалгаанд оролцогсдын үнэлгээг нэгтгэн, сүүлийн гурван жилийн дүнг харьцуулан хүснэгтээр үзүүллээ. “Зээлийн өндөр хүү, богино хугацаа”, “Бодлогын тогтворгүй байдал” гэсэн хоёр асуудлыг сүүлийн хоёр жил дараалан хамгийн тулгамдаж буй асуудлаар нэрлэсэн байна.

Хүснэгт 2. Бизнесийн орчны шийдвэрлэвэл зохих асуудлууд


| | 2016 | 2017 | 2018 |
|---|--|--|--|
| 1 | Төрийн хүнд суртал | Зээлийн өндөр хүү/ богино хугацаа | Зээлийн өндөр хүү/ богино хугацаа |
| 2 | Авилга хээл, хахууль | Бодлогын тогтворгүй байдал | Бодлогын тогтворгүй байдал |
| 3 | Зээлийн өндөр хүү/богино хугацаа | Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ гэх мэт) | Авилга, хээл хахууль |
| 4 | Төрийн албаны нүсэр бүтэц | Хариуцлагагүй, хууль хэрэгждэггүй байдал | Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ гэх мэт) |
| 5 | Шударга бус тендер шалгаруулалт | Авилга, хээл хахууль | Төрийн хүнд суртал |
| 6 | Олон татвар, хураамж | Төрийн албаны нүсэр бүтэц | Хариуцлагагүй, хууль хэрэгждэггүй байдал |
| 7 | Хариуцлагагүй, хууль хэрэгждэггүй байдал | Төрийн хүнд суртал | Төрийн нүсэр бүтэц |

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааг Улаанбаатар хот, орон нутгийн бизнес эрхлэгчдийн дунд асуулгын болон онлайн хэлбэрээр 2019 оны 4-6 саруудад явуулж, нийт 845 аж ахуйн нэгжийг хамруулсан.

Судалгааг хийхдээ МҮХАҮТ-ын гишүүд болон гишүүн бус Улаанбаатар хотын 486, 21 аймгаас нийт 359 аж ахуйн нэгжүүдийг хамруулсан болно.

Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн ерөнхий мэдээллийг дараах инфографикаар үзүүлэв




ХУДАЛДАА
(30%)


ҮЙЛЧИЛГЭЭ
(21%)


БОЛОВСРУУЛАХ
ҮЙЛДВЭР
(12%)



БАРИЛГА
(7%)


ГАЗАР
ТАРИАЛАН
(4%)


МАЛ АЖ
АХУЙ
(4%)


АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ
(6%)


ТЭЭВЭР
(4%)


МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИ,
ХАРИЛЦАА
ХОЛБОО (4%)


УУЛ УУРХАЙ
(4%)


БУСАД
(5%)

Таны бизнесийн дуу хөөлэй

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
МҮХАҮТ-ын байр, М.Гандигийн гудамж, 15-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17011, UB Post – 1010011001
Утас: +976-11310619, Факс: +976-11324620



 www.mongolchamber.mn

 policy@mongolchamber.mn